

**МУИС-ИЙН УТГА ЗОХИОЛЫН ДУГУЙЛАНГИЙН
ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ, ХУВЬСАЛ**

Г. Галбаяр *

Монгол Улсын Их Сургууль байгуулагдсан цагаасаа улс орныхоо олон салбарын хөгжилд чухал хувь нэмэр оруулсаар ирсэн билээ. Хүн ардаа гэгээрүүлэн сэнхэрүүлэх, гоо сайхны таашаал таалал, ухаарал урам өгч хөгжих орчин цагийн монголын уран зохиолын хөгжил хувьсал МУИС-ийн Утга зохиолын дугуйлантай шууд холбоо хамааралтай хөгжиж ирсэн юм. 1945 онд МУИС-д Хэлбичгийн факультет байгуулагдсанаар үндэсний хэлбичиг, урлаг уран зохиол, утга соёлоо дэлгэрүүлэн зааж, судлан шинжлэх үүд хаалга нээгдсэн түүхтэй. Хэлбичиг утга зохиолын тэнхимийг түшиглэн уран зохиол сонирхогч оюутан залуус цуглаж, өөрсдийн шүлэг зохиолоо уншин хэлэлцэж, багш нараасаа үнэлгээ дүгнэлт сонсохын зэрэгцээ цаашдын чиг баримжаагаа олж авч байсан ажээ. Үе үеийн олон залуусын уран бүтээл, эрдэм билгийн эхлэлийг тавьж, монголын уран зохиолын хөгжилд хүндтэй үүрэг гүйцэтгэсээр ирсэн юм, МУИС-ийн Утга зохиолын дугуйлан.

Харин өнөөдрийн хувьд МУИС-ийн Утга зохиолын дугуйлангийн үүсэл, түүхэн хөгжил хувьсал, Монголын уран зохиолын хөгжилд оруулсан хувь нэмрийг ямар нэг хэмжээгээр тодруулах нь чухал асуудлын нэг болжээ.

I. МУИС-ийн Утга зохиолын дугуйлангийн үүсэл, хөгжил хувьсал

МУИС-ийн Утга зохиолын дугуйлангаас эрхлэн тусгай түүврүүд хэвлүүлсээр ирсэн байна. 1957 онд “Идэр оюуны ундраа” гэсэн түүврийг М. Гаадамба багшийн удирдлагаар хэвлүүлжээ. Уг түүврийн дотор талын хавтсан дээр “Улсын их сургуулийн утга зохиолын дугуйлангаас их сургуулийн 15 жилийн ойд зориулан гаргав” хэмээн учир шалтгааныг нь өгүүлжээ. Түүврийн хянан нийтлүүлэгч М. Гаадамба багшийн үгэнд “Манай оюутнуудын дунд сүүлийн 5-6 жилийн дотор уран зохиолын бүлгэм дугуйлан идэвхтэй ажилладаг болсон дээрээс оюутны авьяас билэг өрнөн хөгжиж, ном зохиолыг орчуулахаар барахгүй өөрснөө бичиж зохиох болов. Уран зохиолын дугуйлангийн оюутнуудаас бичсэн шүлэг зохиолыг эмхтгэн “Эхлэлт” гэдэг бичмэл сэтгүүл гаргадаг болсон билээ. Бичмэл сэтгүүлээс тус сургуулийн номын санд тавьж оюутнуудад уншуулах, уран зохиолын бусад бүлгэм дугуйланд явуулан сонирхуулах, солилцох, уншигчдын зөвлөлгөөнөөр хэлэлцүүлэх зэргээр ажиллаж иржээ. Түүгээр ч барахгүй уул сэтгүүлийн зарим дугаарыг тусгайлан нийтлүүлж байсан зэрэг нь оюутнуудын уран

* МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Утга зохиолын тэнхим

бүтээл амжилтыг олж байсны гэрч болно. ... Одоо бид урьдах сайхан уламжлал, зөв эхлэлтийг заншил болгон үргэлжлүүлж, Монгол улсын их сургуулийн арван таван жилийн ойг тохиолдуулан түүнд зориулж, уран зохиолын дугуйлангийн оюутнуудын бичсэн шүлэг, найраглал, үргэлжилсэн зохиол, замын болоод номын тэмдэглэл зэргийг нэгтгэн “Идэр оюуны ундраа” гэдэг эмхтгэлийг нийтлүүлж байна.”¹ хэмээн бичжээ. Энэ баримтаас доорх гаргалгаа гарч байна.

-“Идэр оюуны ундраа” түүврийн анхны дугаарыг М. Гаадамба багшийн удирдлагаар Ч. Алгаа, Ж. Бадамдаш, Ц. Готов, С. Надмид, С. Сандагдорж, Ж. Шагдар нар эрхлэн 1957 онд Улсын хэвлэлийн газар хэвлүүлжээ.

- МУИС-д Утга зохиолын дугуйлан 1950-иад оны эхнээс (*Манай оюутнуудын дунд сүүлийн таваас зургаан жилийн дотор уран зохиолын бүлгэм дугуйлан идэвхтэй ажилладаг болсон*) тогтмол хичээллэж эхэлсэн байна.

- МУИС-ийн Утга зохиолын дугуйлангаас эрхлэн бичмэл хэлбэрээр бусдын хүртээл болгож байгаад “Эхлэлт” гэсэн түүврийг анхлан хэвлүүлжээ. Гиймд “Идэр оюуны ундраа” түүвэр нь “Эхлэлт” түүврийн шууд үргэлжлэл болон гарч эхэлсэн байна.

“Идэр оюуны ундраа” түүврийн хянан нийтлүүлэгчийн үгээс харахад МУИС-ийн Утга зохиолын дугуйлан 1950 оны орчмоос эхлэлээ тавьжээ.

МУИС-ийн Утга зохиолын дугуйлан 1950-иад оноос эхэлж 1960-аад оны үед эрчимтэй хөгжиж байсныг тухайн үеийн дугуйлангийн гол төлөөлөгчид болох Ц. Базаррагчаа дурсамждаа “Уран зохиолын дугуйлан хичээллэх зарлал гарчээ. Товлосон өдрийн цагт нь дугуйланд очтол өнөөх нэг харахад хятад ваарны бөөр шиг, нөгөө харахад олгойтой шар тосны булан шиг толгойтой багш маань сууж байдаг юм байна. Дугуйлан удирдаж явуулдаг багш нь ажээ. Дугуйлангийн эрхлэгч И. Гүрринчин болон Д. Дагдорж /УБДС-ийн багш/, Ц. Готов /Эмэгтэйчүүдийн их эмч/, Ч. Алгаа /Эмэгтэй зохиолч/, Т. Галсан, Г. Жамъяан, Г. Ядамсүрэн, Д. Дорж гээд хэдийнээ төгсөх ангийн оюутнууд “Уран зохиолын цомирлог”, “Туяа” сэтгүүл, “Утга зохиол” сонин мэтэд зохиол бүтээл нь хэвлэгддэг болчихсон улс. Шинэ шүлэг зохиолоосоо уншин шүүн хэлэлцэж байх ажээ. Ажсаад байхад ахлах ангийнхан, шинэ оюутан гэх ялгаа зааг ер алга бололтой. Ана мана хэлэлцэх бөгөөд онолын үүднээс ямар байх тухайд л Гаадамба багшийнхаа амыг харахаас өөр бусад зүйлийг хүн хүн санаанд орсноороо ярих ажээ. Гийм байдлыг Гаа багш ихэд дэмждэг бололтой. Хэний ч шүлэг зохиолын тухай хэн, юу ч гэж ярьж болно. Хэнийх нь үгийг авах, хэнийхийг авахгүйгээ зохиолч өөрөө л мэднэ. Алийг нь авах эсэхээ авах гээхийн ухаанаар шийдэх учиртай. Хүн болгоны хэлснээр засаад байвал зохиол чинь зохиол биш, ер юу ч биш болно гэсэн санааг Гаа багш үе үе цухуйлгах ажээ. Дугуйлангийнхан ч тэр зарчмыг баримталдаг бололтой. ... Дараа дараагийн жилүүдэд дугуйлан улам өтгөрч улам эрчээ аван Б. Жамд гэдэг хөдөөгийн бор хүү мөртөө, хожим өлгийдөө өтөлсөн жаалуудыг хэд нугалахаар сэргэлэн, ухаалаг, овсгоотой, хөдөөгөө ч мэддэг, хотыгоо ч андахгүй болсон эрхлэгчтэй болж Дожоогийн Цэдэв, Шаравын Сүрэнжав, Дамдины Бямбаа, Загарын Сандагаа, Жамбын Дагдондог, Г. Гонгоржав, Т. Юмсүрэн гээд шинэ ч биш, хуучин ч биш уран зохиол, бичиг эрдмийн хорхойтнууд цугладаг, шүүн хэлэлцдэг, шүлэглэн урсгадаг байлаа”² хэмээн утга зохиолын дугуйлангийнхаа ерөнхий өнгө төрх, уур амьсгал хүсэл эрмэлзлэл зэргийг тодорхой бичсэн байна. Энэ нь 1950-иад оны эхнээс үүсэн МУИС-ийн Утга зохиолын

¹ *Идэр оюуны ундраа*. Улсын хэвлэлийн газар, Уб., 1957. 4 дүгээр тал

² МУИС-ийн МХСС-ийн Утга зохиолын тэнхимийн *ДУРСАМЖ-30 жил*. Уб., 2012. 39 дүгээр тал

дугуйлан 1960-аад он болоход хүрээ хязгаараа тэлж, онолын чиг баримжаатай болон өргөжиж, дугуйлангийн удирдагч багшаар Ш. Гаадамба, дугуйлангийн эрхлэгчээр И. Гүрринчин, Б. Жамд нар ажиллаж байсныг гэрчилнэ. Уран зохиол сонирхож МУИС-ийн Утга зохиолын дугуйланд хичээллэдэг оюутан залуусын тухай МУИС-ийн Утга зохиолын дугуйлангийн гишүүн байсан Ардын уран зохиолч Т. Галсан “*Нэг их бахархалтай зүйл бол манай “Утга зохиолын дугуйлан”-д сурдаг бүх хүүхэд онц сурдаг байв. ... Сэтгэн бодож буйгаа үгээр илэрхийлж сурсан хүн онц сурдаг юмуу даа. Ямар ч хүн их утга зохиолгүйгээр боловсролтон болдоггүй, зөвхөн нэг өрөөсгөл мэргэжилтэн болдог юмуу даа*”³ хэмээн гэгээн дурсамж үлдээсэн нь бий. Мөн МУИС-ийн Утга зохиолын дугуйлангийн 1960-аад оны гишүүн Д. Бямбаа дурсамждаа “*Энэ үед Ц. Дамдинсүрэн, Б. Ринчен, Ш. Гаадамба, Ш. Лувсанвандан, Д. Чойжилсүрэн, Т. Пагва, Г. Ринченсамбуу, Б. Жамбалдорж нарын гарамгай эрдэмтэн багш нар Утга зохиолын дугуйланд ихээхэн анхаарал тавьж, санал зөвлөгөө өгдөг байснаас гадна зарим үед Монголын зохиолчдын хорооны дарга, зохиолч Д. Сэнгээ, их зохиолч Д. Намдаг, С. Доржпалам, Ц. Уламбаяр зэрэг зохиолчдыг урин ирүүлж, нэн сайхан яриа өрнүүлдэг байв. Энэ хүмүүс зохиол туурвилын туршлагаасаа ярьж, уран зохиолын онол, дэлхийн сонгодогуудын тухай ярьдаг байсан нь эхлэн бичигч, залуу зохиолчдын билгийн мэлмийг нээхэд үлэмжийн их ач тусаа өгсөн нь эргэлзээгүй*”⁴ хэмээн өгүүлсэн байна. Өөрөөр хэлбэл өгүүлэн буй үед МУИС-ийн Утга зохиолын дугуйлан нэн өргөжиж, эрдэмтэн багш нар төдийгүй нэртэй зохиолчид хүрэлцэн ирж үйл ажиллагаанд нь оролцдог байсныг гэрчилнэ.

1970-1980-аад оны үед МУИС-ийн Утга зохиолын дугуйлангийн тухай дугуйлангийн гишүүн байж, хожмоо энэ дугуйланг олон жил удирдаж байсан С. Дулам багш “*... манай их сургуулийн уран зохиолын дугуйлан хэзээ дээр үеэсээ чөлөөт сэтгэлгээний уурхай байсаар ирсэн юм шүү ...*”⁵ хэмээн дурссан нь уг дугуйлангийн эрэлхийлэл, монголын уран зохиолын хөгжилд оруулсан хувь нэмрийг тодотгосон хэрэг юм. Түүний энэ үзлийг 1980-аад оны дугуйлангийн гишүүн Д. Сумъяагийн “*Дугуйланд шинэ шүлгээ уншина, тэгээд маш идэвхтэй маргаан шүүмж яриа өрнөнө. Нэг удаагийн тийм дугуйлан бүүр шүлгээс хальж үзэл бодол энэ тэрийг ярьсан хэрэг. Лав Төрбат өөр хэн ч байлаа тэд “Энэ гурван сахалт мөнх биш. Бидний бичих зохиол өөр байх ёстой” гэж хүртэл ярьж байсан хэрэг. Гурван сахалт гэдэг нь Маркс, Энгельс, Ленин гурав. Тэр гурвын зураг тэр дугуйлан орсон ангийн хананд өлгөөтэй байсан юм. Тэгэхлээр л бидний үзэл баримтлал бол ер нь заавал марксизмд баригдаж, ганцхан реализмд захирагдахгүй гэж ярьсан хэрэг*”⁶ гэсэн дурсамж бэлхнээ батална. Энэ бодит дурсамжууд монголын уран зохиолын хөгжил хувьсал, түүнд буй болсон шинэ өнгө аяс, эрэл хайгуул, ололт амжилт энэ дугуйлангаас ундаргатай байсныг гэрчилнэ. Энэ үед яруу найрагч Д. Нямаа

Дуу шүлэг мөрөөдөлтэй юмсан ...

Дулам багшийн дугуйлан санагднам

Оюутан цагийн цэлмэг дуртгалын

Оддын бороонд нялхран зогсном!

Таван хормын шүлгээр уралддагсан

³ МУИС-ийн МХСС-ийн Утга зохиолын тэнхимийн *ДУРСАМЖ-30 жил*. Уб., 2012. 49 дүгээр тал

⁴ МУИС-ийн МХСС-ийн Утга зохиолын тэнхимийн *ДУРСАМЖ-30 жил*. Уб., 2012. 50-51 дүгээр тал

⁵ МУИС-ийн МХСС-ийн Утга зохиолын тэнхимийн *ДУРСАМЖ-30 жил*. Уб., 2012. 66 дугаар тал

⁶ МУИС-ийн МХСС-ийн Утга зохиолын тэнхимийн *ДУРСАМЖ-30 жил*. Уб., 2012. 82 дугаар тал

*Тасалгаан дундуур догдлол нисдэгсэн
Хэн нэгний үзэгний дүүлэх чимээ л
Хээр талын морьтон шиг төвөргөөнтэйсэн
Агшин, агшинаа хөөцөлдөн урсаж
Амьдрал мөрөн наран зүг оджээ,
Гэрэлт солир шиг залуу насаан*

Гээхгүй юм шиг эндүү боджээ! ... (Авьяас билгийн охь. /МУИС-ийн 70 жилийн ой, Утга зохиолын тэнхим байгуулагдсаны 30 жилийн ойд зориулсан түүвэр/ Уб., 2012. 338 дугаар тал) гэх зэргээр шүлэглэсэн “Дулам багшийн дугуйлан” гэдэг шүлэг бичсэн нь түүхэн гэрч болон үлджээ.

1980-аад оны сүүл 1990-ээд оны эхээр ороо бусгаа нийгмийн хаялага цацлагад МУИС-ийн Утга зохиолын дугуйлан тодорхой хэмжээгээр өртөж тасалдахад хүрсэн ч өөрсдийгөө 1990-ээд оныхон хэмээн овоглодог залуус, МУИС-ийн Утга зохиолын тэнхимийн багш Д. Галбаатарын удирдлагаар их сургууль дээр цугларч зохиол бүтээлээ туурвиж, шинэ эрэл хайгуул хийж, “Чөлөөт сэтгэлгээний дуулал” гэсэн яруу найргийн наадам хийж эхэлсэн нь одоо хүртэл үргэлжилсээр байна.

Сүүлийн жилүүдэд буюу 2010-аад оноос МУИС-ийн утга зохиолын дугуйлангийнхан өөрсдийн бүтээлүүдээрээ “Бүтээлийн эмхэтгэл-1”, “Хөх мэдрэхүй” тэргүүтэй түүврүүд хэвлүүлж, Монголын зохиолчдын эвлэл болоод бусад их, дээд сургуулийн мэргэжил нэгт нөхөдтэй харилцаа холбоогоо өргөжүүлэн үйл ажиллагаагаа эрчимжүүлж байна.

II. МУИС-ийн Утга зохиолын дугуйлангийн монголын уран зохиолын хөгжилд оруулсан хувь нэмэр

МУИС-ийн Утга зохиолын дугуйлангийнхан өөрсдийн шүлэг найраг, зохиол бүтээлээсээ дээжлэн “Эхлэлт” нэртэй түүврийг анх хэвлүүлснээс хойш “Идэр оюуны ундраа” нэртэй цувралуудыг хэвлүүлж байсан ч 1980-аад оны “Цог” сэтгүүлийн “Оч” булан, “Утга зохиол” сонины “Шинэ танил” буланд их сургуулийн утга зохиолын дугуйлангийнхны бүтээл хэвлэгдэх болсон түүх харагдаж байна.

МУИС-ийн Утга зохиолын дугуйлангаас эрхлэн гаргасан түүврүүдийг дэс дараалуулан уншсаны дараа уран зохиолын тухай зөв мэдрэмж, эрэл хайгуул, чөлөөт сэтгэлгээ, түүний урлал энд дархлагдаж байжээ гэсэн дүгнэлтэд хүрч байна. Учир нь энэ дугуйлангийнхан ямар нэг захиалга, шахалт дарамтад оролгүй зөвхөн авьяас билигт хөтлөгдсөн түүнийгээ тогтолцоотой онол судлалаар баяжуулан туурвиж ирсэн тул тэдний зам мөр урт, үйлс гэгээн явж иржээ.

“Их сургуулийн янз бүрийн мэргэжлийн ангиуд, тэдгээрийн дотроос монгол хэл, утга зохиолын анги олон зохиолчдыг төрүүлжээ. Үүнд: Д. Цэвэгмэд, Ч. Лодойдамба, П. Хорлоо, Х. Пэрлээ, Э. Оюун, М. Гаадамба, Ч. Чимид, С. Эрдэнэ, С. Доржпалам, Д. Тарваа, Д. Даржаа, Д. Мягмар, Д. Гомбожав нарын зэрэг зохиолчид хийсэн бүтээлээрээ товойн гарч өргөн олондоо нэр хүнд оллоо.”⁷ Өмнөх үеийнхнийхээ зам мөрийг их сургуулийн утга зохиолын дугуйлангийнхан бүрэн дүүрэн үргэлжлүүлж чадсаныг түүхэн баримтууд батлаж байна. “Улсын их сургуулийн оюутны уран зохиолын дугуйлан бол чухамхүү идэр оюуны ундраа мөн. Дэлхий дахины нэрд гарсан их зохиолчийн

⁷ *Идэр оюуны ундраа*. Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. Уб., 1962. 3 дугаар тал

намтар түүхийг үзвэл эрдэм номыг сурч хүмүүжсэн өөрийн сургуулийн сурагчдын бичмэл сэтгүүлд зохиолоо анх нийтлүүлж, уран бүтээлийн их замаа эхэлсэн нь цөөнгүй байна. Монгол улсын их сургуулийн оюутнуудын авьяас билэг, эрдэм мэдлэг нь хаврын ногоо шиг юунд ч сааталгүй урган цэцэглэж, намрын жимс шиг зүй тогтоолоороо төгс боловсрон, тэдний дундаас хойч өдөр манай ард түмний оюун билгийг алдаршуулан гайхуулах бичгийн мэргэд, суут уран бүтээлч “Од шиг гэгээн цэцэн ухаантан” олноор төрж гарах нь эргэлзээгүй”⁸ гэж бичиж байсны бодит гэрч нь МУИС-ийн Утга зохиолын дугуйлангаас Монголын уран зохиолын гол зохиолчид, судлаач шүүмжлэгчид төрж гарсан явдал юм. Тийм ч учраас МУИС-ийн Утга зохиолын дугуйлангийн түүхэн замнал, хэтийн төлөвийн талаар Д. Галбаатар багш “МУИС-ийн Утга зохиолын нэгдэл бол монголын орчин үеийн уран зохиолын үе үеийн уран дархчуулыг төрүүлсэн урлах эрдмийн уурхай юм. ... Удахгүй уран зохиолд дахин нэг тэсрэлт эндээс эхэлнэ гэдэгт итгэж явдаг”⁹ хэмээн өгүүлсэн нь нэгийг хэлнэ.

МУИС-ийн Утга зохиолын дугуйлангаас эрхлэн хэвлүүлсэн бүтээлүүд ямар нэг шинэ эрэлхийлэл, үгийн урлалын увдис шидтэй нарийн уялдаа холбоотой нь харагдаж байна. Тухайлбал, Их сургуулийн хөгжил дэвшил юунаас ч үл хамааран мандан бадарч байгаа үйл хэргийг:

... Тайван чөлөөтэй
 өрнөн дэгжиж байгаа
Талын монголын
 их сургууль маань
Өглөөний нарнаас ч
 тунгалаг гэрэлтэй
Өнөд эрдэнээс ч
 бидэнд хайртай
Униарт талын маань
 чимэг болон мандаж байна
Ууган соёлын маань

төв болон сүндэрлэж байна ... (Ж. Бадамдаш “Алдарт ой”) /Идэр оюуны ундраа. Уб., 1957. 22 дугаар тал/ хэмээн их сургуулийнхаа хөгжил дэвшилээр бахархан омогшиж шүлэглэхийн зэрэгцээ их сургуулийн хайр ивээл, хишиг буяныг давхар илэрхийлсэн байхад өвөг дээдсийнхээ үлдээсэн өв соёлоороо бахархан баярлаж,

Ухаан төгс өвгөдийн маань ач бидэндээ үлдээсэн
Улирагч олон зууныг туулан хүрч ирсэн
Талын цэцгийн үнэрийг мөр бүрдээ шингээсэн
Тансаг яруу найргийн эртний шимтэй охь ...
Монголын нууц товчоо гүнд нь хүршгүй далай юм

Мохошгүй билэг авьяастныг өөртөө татах соронзон юм (Б. Жамд “Монголын нууц товчоо”) /Идэр оюуны ундраа. Уб., 1962. 9 дүгээр тал/ гэж монголчуудын түүхэн замнал, оюуны соёлын бахархал болсон зохиол бүтээлийн ач холбогдлыг урнаар бичсэн байна.

⁸ Идэр оюуны ундраа. Улсын хэвлэлийн газар, Уб., 1957. 5 дугаар тал

⁹ Бүтээлийн эмхтгэл-I. /МУИС-ийн Утга зохиолын нэгдлээс эрхлэн гаргасан түүвэр/ Уб., 2007. 6 дугаар тал

XX зууны монголын уран зохиолын өгүүллэгийн нэрт төлөөлөгчдийн нэг Ц. Базаррагчаа “Нөөцлөгдсөн хүн” өгүүллэгтээ “Цэлмэг тэнгэрт хөмсгөн сар алгуурхан аялна. Сарны тунгалаг гэрэлд навчсаа хийсгээж байгаа тэр нэгэн улиас өрмөө чамласан жаал нулимсаа унагаахын адил харагдана” /Идэр оюуны ундраа. Уб., 1962. 45 дугаар тал/ хэмээн бүтээгүй хайрын бүдэг дурдатгал болсон өгүүллэгийн утга агуулгыг тодруулах үүднээс байгалийн зураглалыг урнаар урлаж чадсан нь хожмын туурвин бүтээх их аяных нь эхлэлийг харуулна. XX зууны монголын уран зохиолын нэрт төлөөлөгчдийн нэг эрдэмтэн зохиолч Д. Цэдэв төрж өссөн нутаг орныхоо тухай бичсэн “Эх нутгийн тухай тэмдэглэл” шүлэгтээ,

*Унасан нутгийнхаа хил дээр ирэхэд
Урин салхи урдаас сэвэлзэнэ
Эх нутгийн бүхий л анхил үнэрийг
Эгээ л надад авчирсан шиг санагдана
Эрүүл царай хүрэл адил гялалздаг нь
Энэ биед бул адил булчин зангирдаг нь
Эм болсон, нутгийн ариун салхи л*

Эс болгонд минь цогцлонхон байдгийнх юм /Д. Цэдэв 1962/ хэмээсэн хүнд төрсөн нутаг ус хэрхэн хүч чадал, итгэл найдвар, ивээл хайраа хүртээдэг далд холбоос мөн чанартайг бодрол бясалгалын уянгаар уянгалуулсан байна. Тэгвэл манай нэрт яруу найрагч Т. Галсан гуайн ертөнцийн мөн чанар, учир утгыг тайлбарлан таниулахыг эрмэлзсэн ухаарал бясалгалын,

*Хөөрхний хойноос хөөцөлдөж явагч
Хүүхний сайхнаас төөрч явдаг
Алд биеийн амрыг хайгч
Амьдралын гайхамшигаас зугатааж явдаг*

* * *

*Хүүхдийн инээднээс сайхан
Хөгжмийн эгшиг сонссонгүй
Эхийн цагаан сүүнээс*

Илүү амттаныг амссангүй /Т. Галсан “Уянгын бадгууд” 1962/ гэсэн мөрүүд ч уншсан хэн бүхэнд нэгийг бодогдуулж, хоёрыг сануулна.

Эдгээр жишээ шүлгүүдээр дээжлэгдсэн МУИС-ийн Утга зохиолын дугуйлангийнхны үе үеийн бүтээлүүдээс баяр хөөрөөр бялхаж, хойч ирээдүйдээ итгэл төгс байгаа залуу хүмүүсийн урам зориг, урагшаа тэмүүлсэн хүсэл мөрөөдлийн илэрхийлэл нэвт харагдаж байна. Харин уран сайхны хувьд бие биенээ давтан дуурайсан, хэт чамирхан дэгжирхсэн болох нь цөөнгүй. Гэхдээ “Идэр оюуны ундраа” /Уб., 1957, 1960, 1962, 1964, 1967/, “Чөлөөт сэтгэлгээний дуулал” /Уб., 1993/, “Бүтээлийн эмхтгэл-1” /Уб., 2007/, “Хөх мэдрэхүй” /Уб., 2010/ зэрэг МУИС-ийн Утга зохиолын дугуйлангаас эрхлэн хэвлүүлсэн бүтээлүүд цаг үе бүрийнхээ тусгал болж, шинийг эрэлхийлж, урагшаа тэмүүлсэн тэмүүлэл дүүрэн болох нь харагдаж байна. Эдгээр түүврүүдэд шүлэг зохиолоо хэвлүүлж, их сургуулийн дугуйланд суралцагсад хожимоо монголын утга зохиолын үе үеийн гол төлөөлөгчид болсон түүхтэй. Энэ бол МУИС-ийн Утга зохиолын дугуйлангийн эрхэм чухал бахархал болжээ.

Дүгнэлт

МУИС-ийн Утга зохиолын дугуйлан 1950-аад оноос үүсэж, үл тасалдан үйл ажиллагаагаа явуулж ирсэн ч 1960, 1980, 1990, 2010 онуудад эрчимтэй үйл ажиллагаагаа өрнүүлсээр ирсэн байна.

МУИС-ийн Утга зохиолын дугуйлан нь авьяас билигтэй залуусыг хүсэл сонирхол, тэмүүлээр нь урин дуудаж, тэдний уран зохиолын авьяас билгийг онол-судлалын тогтолцоотой мэдлэгээр хөгжүүлдэг тул энэ дугуйлангийнхан хожим сайн зохиолчид болдог онцлогтой ажээ. Тиймд МУИС-ийн Утга зохиолын дугуйлангаас Монголын уран зохиолын гол төлөөлөгчид болох зохиолчид, судлаачид олноороо төрж гарчээ.

МУИС-ийн Утга зохиолын дугуйлангийн түүхэн хөгжил хувьсал, мөн чанар, үе үеийн төлөөлөгчдийн бүтээл туурвилыг аваад үзэхэд Монголын утга зохиолын түүхэн хөгжилд чухал хувь нэмэр оруулж ирсэн болох нь харагдаж байна.

НОМ ЗҮЙ

1. *Авьяас билгийн охь*. /МУИС-ийн 70 жилийн ой, Утга зохиолын тэнхим байгуулагдсаны 30 жилийн ойд зориулсан түүвэр/ Уб., 2012
2. *Идэр оюуны ундраа*. Уб., 1957
3. *Идэр оюуны ундраа*. Уб., 1960
4. *Идэр оюуны ундраа*. Уб., 1962
5. *Идэр оюуны ундраа*. Уб., 1964
6. *Идэр оюуны ундраа*. Уб., 1967
7. *Чөлөөт сэтгэлгээний дуулал*. Уб., 1993
8. *Бүтээлийн эмхтгэл-I*. /МУИС-ийн Утга зохиолын нэгдлээс эрхлэн гаргасан түүвэр/ Уб., 2007
9. *Хөх мэдрэхүй*. Уб., 2010
10. Галбаатар Д. *Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд*. Уб., 2003
11. Галбаатар Д. *Эрин цаг-зохист аялгуу-зохиолч-унишигч II*. Уб., 2011
12. Галбаяр Г. *XX зууны монголын уран зохиолын хөгжлийн үе шатууд*. Уб., 2004
13. *Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх*. Уб., 1968
14. *Монголын орчин үеийн уран зохиолын түүх*. I-III боть. Уб., 1985, 1989, 1998
15. МУИС-ийн МХСС-ийн Утга зохиолын тэнхимийн *ДУРСАМЖ-30 жил*. Уб., 2012